

Сайн дурын үйл ажиллагаа гэж юу вэ?

Сайн дурын үйл ажиллагаа гэдэг нь бусдын тусын тулд буюу тэдний аз жаргал, сайн сайхны төлөө үйлчлэх хүсэл эрмэлзлэл юм. Энэ эрмэлзэл нь хүмүүсийн бие биенээ дэмжин амьдрах байгалиас заяасан жам ёсны мөн чанар юм.

Сайн дурын үйл ажиллагааны шинж чанар

- Сайн дурын идэвхтэний өөрийн хүсэл сонирхолын дээр үндэслэн хийгдэнэ.
- Аливаа үйл ажиллагаа нь ямар нэг цалин, урамшуулал гэх мэт санхүүгийн дэмжлэггүй байна.
- Хийгдэж буй үйл ажиллагаа нь олон нийт болон сайн дурын идэвхтэнд харилцан үр ашигтай (үр шимтэй) байна.
- Сайн дурынхны үйл ажиллагаа нь өөр хэн нэгэнд ашиг, олз авчрах зорилгогүй байна.
- Зарим тохиолдолд тухайн ажил үүргийг гүйцэтгэх сайн дурын идэвхтнийг тусгайлан томилох бөгөөд зөвхөн томилогдсон идэвхтэн тухайн ажлын байран дээр тогтвор суурьшилтай ажиллана. Энэ тохиолдолд тухайн ажлын гүйцэтгэлээс хамаарч урамшуулал олгогдож болдог.

Сайн дурын үйл ажиллагааны үндсэн 4 хэлбэр

1. Харилцан туслалцаа үзүүлэх буюу өөртөө туслах сайн дурын үйл ажиллагаа.
2. Бусдад энэрэн нигүүлсэх үйлсийн үйлчилгээ үзүүлэх сайн дурын үйл ажиллагаа
3. Нийгмийн төлөө аливаа үйл ажиллагаанд оролцох сайн дурын үйл ажиллагаа
4. Бусдыг өмгөөлж, тэднийг хамгаалах, компанит ажилд оролцох сайн дурын үйл ажиллагаа зэрэг болно.

Сайн дурын үйл ажиллагааны ач холбогдол

Нийгмийн талаас:

Сайн дурын үйл ажиллагаа нь нийгмийн хөгжлийн салбарт ядуурлыг бууруулах, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх үйл ажиллагаанд тодорхой хэмжээгээр хувь нэмрээ оруулж зохих үүрэг гүйцэтгэдэг.

1. Сайн дурын үйл ажиллагаа нь тухайн нийгэмд эдийн засгийн чухал хувь нэмэр оруулдаг.

2. Олон нийтийн оролцоог дэмжих явдал аливаа нийгмийн хөгжил, удирдлагын сайн тогтолцооны салшгүй хэсэг болж ирсэн. Иймээс сайн дурын үйл ажиллагаанд оролцоно гэдэг нь хувь хүн иргэнийхээ үүргийг биелүүлж итгэл үнэмшилтэй, илүү тогтвортой нийгэм байгуулахад хувь нэмрээ оруулж байгаа гэсэн үг юм.

3. Сайн дурын үйл ажиллагаанд оролцох нь нэгэн хэв загварт орж гадуурхагдаж байгаа мэт сэтгэгдэл төрж суугаа хүмүүст нийгэмдээ илүү ойртож, нийгэмд эзлэх өөрийн байр сууриа олж авахад тусалдаг.

4. Сайн дурын үйл ажиллагаа нь ажилгүй хүмүүсийг ажлын байраар хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Сайн дурын үйл ажиллагаанд хүчин зүтгэх нь шинэ ажлын байр буй болгох замыг нээж өгөх бөгөөд, хэрэв та үр бүтээлтэй, шаардлагатай үйлчилгээг санаачилж чадвал төрийн аливаа байгууллага таны ажлыг дэмжиж хамтран ажиллаж болох юм.

Хувь хүн талаас:

Хүмүүс бусдад тусламж дэмжлэг үзүүлэхийг хүссэн үедээ сайн дурын үйл ажиллагаанд оролцдог. Гэхдээ сайн дурын идэвхтэнүүд өөрсдийн эрх ашиг, тусын тулд энэхүү үйл ажиллагаанд оролцдог байж болно. Ихэнх хүмүүс сайн дурын үйл ажиллагаанд оролцсоноор асар их ашиг олдог гэж ойлгодог ч түүхээс үзэхэд сайн дурын үйл ажиллагааг хувиа бодох үзэлгүй, нийтэч, энэрэнгүй сэтгэлтэй хүмүүсийн өглөг буяны нэг хэлбэр гэж үзсээр иржээ. Сайн дурын үйл ажиллагаа нь бусдын төлөө гэсэн хүсэл эрмэлзэл дүүрэн байдаг тул туйлын эрхэм дээд үйлсэд тооцогддог.

Сайн дурын үйл ажиллагааны талаарх үзэл баримтлалууд

Сайн дурын үйл ажиллагааны талаар маш олон үзэл баримтлалууд байдаг бөгөөд хамгийн өргөн хэрэглэгддэг үзэл баримтлалуудаас дурдвал:

Харилцан бие биедээ туслах үзэл баримтлалын хувьд тухайн үйл ажиллагааны хүрээнд ашиг тус хүртэж буй хувь хүн, хэсэг бүлэг хүмүүс болон олон нийт харилцан бие биеэсээ үр шимийг хүртэж буй явдал юм. Үүний дүнд шинэ зүйлийг сурч мэдэж, ашиг тусыг хүртэх ба бусдад сайн дурын тусламж, халамж үйлчилгээ хэрэгцээтэйг ойлгох явдал юм.

Чадавхжуулах үзэл баримтлалын хувьд харилцан мэдлэг туршлагаа солилцсоноор өөрөө өөрийгөө хүчирхэг, хүнд хэрэгтэй хүн болохыг мэдэрч, бусдад туслах хүсэл эрмэлзлэлийг бий болгох зэргээр хувь хүнийг чадавхжуулах явц юм. Жишээлбэл сүрьеэ өвчний талаар өөрийн мэдлэгээ бусдад хуваалцах, уг өвчин эдгэрдэг болохыг олон нийтэд ухуулан ойлгуулах, эрүүл мэндээ хамгаалах энгийн мэдлэгийг олон нийтэд олгосноор тухайн орон нутагт хэл нэвтрэлцэхгүй эсвэл эмнэлгийн тусламж үйлчилгээг яаралтай авч чадахааргүй хол байрлаж байгаа зэрэг тохиолдолд өөрөө өөртөө анхан шатны тусламжийг үзүүлж чадах гэх зэргээр өөрөө өөртөө туслах боломж нээгдэнэ.

Бусдаас суралцах үзэл баримтлалын хувьд өөрийн хүрээлэн байгаа орчин, гэр бүлийн гишүүд, олон нийтээс суралцах, тэднийг даган дуурайх хэлбэр юм. Өөрөөр хэлбэл гэр бүлийн хэн нэгэн гишүүн сайн дурын үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог ба энэ нь олон нийт болон хувь хүнд тодорхой тусламж үзүүлж байгаа нь тухайн хүнийг сайн дурын идэвхтнээр ажиллах хүсэл сонирхлыг бий болгох зэрэг үйл явц юм.

Эрүүл мэндийн сайн дурын идэвхтэн /ЭМСДИ/ гэж хэн бэ?

ЭМСДИ-д зайлшгүй байх чанарууд

Нууцыг хадгалах:

ЭМСДИ сүрьеэгээр өвдсөн хүн хоёрын хоорондын харилцааны хамгийн гол зүйл бол итгэл. Нууцыг хадгалах нь ЭМСДИ болон сүрьеэгээр өвчилсөн хүн хоёрын хоорондын итгэлцлийг бий болгоход чухал үүрэгтэй. Итгэлийг нь олж чадсан нөхцөлд л таны өгч буй мэдээллийг илүү нааштай хүлээн авна.

«ЭМСДИ гэдэг нь эдийн засгийн сонирхолгүйгээр өөрийн дур хүслээр хэн нэгний төлөө аливаа сайн үйл бүтээх зорилго бүхий хүн юм»

ЭМСДИ та эм ууж буй хүний ярьсан болгоныг хүндэтгэх хэрэгтэй. Мөн та түүний зөвшөөрөлгүйгээр түүний тухай ямар ч зүйлийг бусдад хэлэх ёсгүй.

Эм ууж буй хүн өөрт тулгараад байгаа хүндрэл бэрхшээл, нөхцөл байдлыг илэн далангүй ярих нь зүйтэй гэдгийг түүнд ойлгуулах үүрэгтэй.

Санаа тавих:

Бусдад тусалж байгаа үед анхаарал халамж тавьж байх нь маш чухал. Энэ байдлаа тусархаг, нөхөрсөг, эелдэг байх, халуун дотно хандах, сэтгэлийн дэм өгөх зэргээр илэрхийлж болно.

Зовлонгоос хуваалцах:

ЭМСДИ нь нөхцөл байдлыг сүрьеэгээр өвчилсөн хүний байр сууринаас ойлгох ёстой. Зовлонгоос хуваалцах үед тухайн хүнийг ойлгож мэдэрч байдаг бол өрөвдөнө гэдэг нь түүнийг ийм байдалд орсонд харамсаж байна гэсэн үг. Өрөвдөн хандаж байгаа үед тэр хүнд таны ярилцлага найдвар төрүүлэхгүйгээр зогсохгүй өөртөө харамсахад хүргэдэг.

Хүлээн зөвшөөрөх:

ЭМСДИ эм ууж буй хүнээ байгаагаар нь хүлээн авах хэрэгтэй. Та эмчлүүлэгчийнхээ нөхцөл байдалд шүүмжлэлтэй хандаж болохгүй. Өөрөөр хэлбэл та хэдий түүнээс өөрөөр бодож байвч түүний үзэл бодол, хандлага болон зан байдлыг хүндэтгэх хэрэгтэй.

Ялгаварлан гадуурхах:

Энэ нь тухайн хүнийг сүрьеэгээр өвчилсөнтэй нь холбогдуулан хувь хүн эсвэл бүлэг хүмүүс, нийгмээс өөрөөр харьцах буюу ялгаж хандана гэсэн үг юм.

Яагаад ялгаварлан гадуурхаж байна вэ? Сүрьеэгийн талаар хүмүүс үнэн зөв ойлголтгүй байдагтай холбоотой. Сүрьеэ өвчин амьсгалын замаар халдварладаг гэсэн үзэл бодлоос үүдээд сүрьеэ өвчтэй хүнтэй ойр байвал өөрийгөө энэ өвчний халдвар авна гэж айдаг. Үүнээс үүдээд найз нөхөд, гэр бүл, нийгэм тэр ч байтугай эрүүл мэндийн байгууллагын ажилтнууд ч сүрьеэгээр өвчилсөн хүмүүсийг ялгаварлан гадуурхахад хүрдэг. Харин сүрьеэгээр өвчилсөн хүний хувьд бусдад сүрьеэтэй гээд хэлчихвэл цаад хүн нь надаас сэжиглэнэ гэж боддог. Сүрьеэгийн талаархи дээрхи ташаа ойлголт, айдсыг хүмүүст зөвөөр ойлгуулах шаардлагатай. Сүрьеэгээр өвчилсөн хүмүүс нийгмийн ялгаварлан гадуурхлаас эмээсний улмаас эмчлүүлэхгүй үлдэх, эмчилгээнээс татгалзах, эмчилгээгээ хаях зэрэг үйлдлийг хийдэг. Энэ байдлаас халдвар цааш тархах аюултай.

Гэхдээ сүрьеэгийн халдвартай хэлбэрийг эмнэлэгт эмчлээд бусдад халдвар тараахгүй болсон тохиолдолд гэрээр нь эмчилдэг. Сүрьеэгийн эмчилгээг тасралтгүй, зөв хийсэн тохиолдолд сүрьеэ эдгэрдэг өвчин болох нь хэдийнэ батлагдаад байна.

Сүрьеэ өвчний тухай

Сүрьеэгийн нян нь хүний биеийн аль ч хэсгийг гэмтээж болох бөгөөд ихэвчлэн уушгийг гэмтээдэг.

Сүрьеэ өвчнийг дотор нь уушигны болон уушигны бус эрхтэний сүрьеэ гэж ангилдаг.

Уушгины хэлбэрийн сүрьеэ нь халдвартай ба халдваргүй гэж байх ба бусад эрхтэний сүрьеэ нь халдваргүй.

Уушгины халдвартай хэлбэрийн сүрьеэтэй өвчтөн ярих, дуулах, хашгирах, найтаах ялангуяа ханиалгахад сүрьеэгийн нян агаарт цацагдаж, энэхүү сүрьеэгийн нян агуулсан агаараар амьсгалсанаар халдвар авна. Шинэ эзний биед нянгийн үржих тохиромжтой хэсэг нь уушги юм. Уушгинаас нян цусаар дамжин бусад эрхтэн тогтолцоонд очдог.

Сүрьеэ гэдэг нь сүрьеэгийн савханцар хэмээх нянгаар үүсгэгддэг, амьсгалын замаар дамжин халдварладаг халдварт өвчин.

Зөвхөн уушгины халдвартай хэлбэрийн сүрьеэтэй өвчтөн л халдвар тараах боломжтой юм.

Сүрьеэ өвчний үед илрэх шинж тэмдэгүүд

Сүрьеэ өвчний үед илрэх шинж тэмдэгийг ерөнхий, уушгины сүрьеэгийн үед гарах, уушгины бус сүрьеэгийн үед гарах гэж ерөнхийд нь 3 ангилдаг

1. Сүрьеэ өвчний үед илрэх ерөнхий шинж тэмдэг:
 - Халуурах
 - Шөнө хөлрөмтгий болох
 - Жин буурах, турах
 - Ядрах, сульдах
 - Хоолны дуршил буурах

2. Уушгины сүрьеэ өвчний үед илрэх шинж тэмдэг:

- Хуурай эсвэл цэртэй ханиалгах - Уушгины сүрьеэтэй хүний ханиалгын онцлог нь тасралтгүй 14 хоног ба түүнээс дээш хугацаагаар ханиалгана.

- Цээжээр өвдөх
- Амархан амьсгаадах
- Цустай цэр гарах

Сүрьеэ өвчний үед илэрдэг гол шинж тэмдэг нь 14 хоног ба түүнээс дээш хугацаагаар ханиалгадаг. Хэрэв ийм шинж тэмдэг илэрвэл яаралтай харьяа аймаг дүүргийн сүрьеэ диспансерийн эмчид хандах хэрэгтэй.



3. Уушгины бус сүрьеэ өвчний үед илрэх шинж тэмдэг:

- Өвдөх, хавдах, овойх
- Ямар эрхтэнд эмгэг өөрчлөлт үүссэнээс шалтгаалан шинж тэмдэг гарна.

Сүрьеэгийн эмчилгээ

Сүрьеэгийн нянг устгах чадвартай эмүүдийг сүрьеэгийн эсрэг эмүүд гэнэ.

Сүрьеэгийн эсрэг эмчилгээнд зөвхөн сүрьеэгийн нянгийн эсрэг өвөрмөц үйлчилгээтэй хэд хэдэн эмийг хавсран хэрэглэдэг. Эдгээр эмүүд нь сүрьеэгийн нянгийн эсрэг тус тусдаа үйлчилгээтэй ба хавсруулан хэрэглэх нь нян эдгээр эмүүдэд тэсвэртэй болохоос урьдчилан сэргийлнэ.

Сүрьеэгийн эмчилгээ нь эрчимт ба үргэлжлэх шат гэсэн 2 хэсгээс тогтоно.


Эрчимт эмчилгээний шатанд 4-5 эм хэрэглэх бөгөөд 2-3 сар үргэлжилнэ. Өвчтөний зовиур, шинж тэмдэг арилж эхэлнэ. Үргэлжлэх шатны эмчилгээ 4-6 сар үргэлжилнэ.

Сүрьеэгийн эмийн зохистой хэрэглээг сайжруулах үүднээс Тогтсон Тунтай Хослол (ТТХ) буюу сүрьеэгийн эсрэг хэд хэдэн эмийг нэг шахмалд агуулсан бэлдмэлийг Монгол улсад 1999 оноос хэрэглэж эхэлсэн.

ТТХ давуу тал нь:

- өвчтөний эмээ ууж байгаа эсэхийг хянахад хялбар,
- эмчилгээний зөв хослол хэрэглэх,
- аль нэг эмийг уухгүй үлдээх зэргээс сэргийлэх,
- сүрьеэгийн эсрэг эмийг өөр эмгэгийн үед хэрэглэх байдлаас сэргийлэх,

Сүрьеэгээр өвчилсөн хүн эмчилгээгээ горимын дагуу, бүрэн хийлгэвэл сүрьеэ өвчин төгс эдгэрнэ.



Шууд хяналттай эмчилгээ гэж юу вэ?

Эмчийн заасан горимын дагуу эмчилгээг үр дүнтэй явуулах сонгомол арга нь шууд хяналттай эмчилгээ юм.

Эмчилгээг шууд хяналттай хийнэ гэдэг нь эмч, эмнэлгийн ажилтан, сайн дурын идэвхтэн өвчтөний эмийг харж байгаад уулгахыг хэлнэ.

Сүрьеэгийн эмчилгээ эхлээд сарын дотор өвчтөний зовиур арилдаг. Өвчтөн зовиур арилсаныг эдгэрлээ гэж ойлгосноос эмээ өдөр бүр тогтмол уухгүй орхидог, мартдаг. Энэ нь цаашид эмчилгээ үр дүнгүй болох, улмаар эмэнд дасалтай сүрьеэ үүсэх боломжийг ихэсгэнэ. Иймээс дээрх хор уршгаас сэргийлэхийн тулд өвчтөнийг шууд хяналттай эмчлэх явдал чухал байдаг. Өвчтөн нэг удаа эмчилгээндээ ирээгүй тохиолдолд түүнийг эрж олон эмчилгээг үргэлжлүүлэх шаардлагатай.

Эмчилгээг хяналттай хийснээр :

- Эдгэрэлтийн түвшин нэмэгдэнэ.
- Сүрьеэгийн нас баралт, өвчлөл, тархалт буурна.
- Эмэнд дасалтай сүрьеэ үүсэхээс сэргийлнэ.

Эмчилгээг хяналтгүй хийснээр:

- Эмчилгээ үр дүнгүй болно.
- Өвчин архагшина.
- Өвчлөл, тархалт, нас баралт ихэснэ.
- Эмийн дасалтай сүрьеэ үүснэ.
- Бусдад халдвар тараана

Иймээс эмчилгээг хяналттай хийх нь хувь хүн төдийгүй нийгэмд ач тустай эмчилгээний арга юм. Сүрьеэгийн эмчилгээг эхэлсэн бол өвчтөнөө эдгээж эмчилгээг бүрэн төгс хийж дуусгах нь маш чухал. Харин эмчилгээгээ дуусгах боломжгүй үед эмчилгээ эхлэхгүй байх нь дээр гэж үздэг. Учир нь төгс бус, дутуу эмчилгээ нь эмэнд дасалтай сүрьеэгийн аюулыг нэмэгдүүлдэг..

Эмийн дасалтай сүрьеэ гэж юу вэ?

Сүрьеэгийн нян сүрьеэгийн эсрэг эмчилгээнд хэрэглэдэг эмүүдэд устахаа больж, дасалтай болохыг эмэнд дасалтай сүрьеэ гэнэ.

Өвчтөнг бүрэн төгс эмчлэхгүй дутуу орхих тусам өвчтөний биед байгаа эмэнд мэдрэг нянгийн тоо багасч, эмэнд дасалтай нянгийн тоо ихэсч эмэнд дасалтай сүрьеэ үүсдэг.

Эмчилгээгээ дутуу орхин эмэнд дасалтай сүрьеэгээр өвчилсөн хүн бусдад халдвараа тарааж байдаг нь хамгийн аюултай гамшиг юм. Эмэнд дасалтай сүрьеэгийн халдвар авч өвчилсөн хүн эмчилгээгээ хичнээн сайн хийлгэсэн ч өвчин үүсгэсэн нян нь эмэнд дасалтай тул эдгэрэх боломж нь багасдаг.

Эмэнд дасалтай сүрьеэг хүн өөрөө үүсгэдэг.

Үүний гол шалтгаан нь: Сүрьеэтэй өвчтөнийг эмчилгээний буруу горимоор эмчлэх, сүрьеэгийн эмийг замбараагүй хэрэглэх, эмчилгээгээ таслах, эмчилгээг хяналттай хийгээгүйгээс ихэвчлэн үүснэ.

Олон эмэнд дасалтай (Multi Drug resistance) сүрьеэ буюу сүрьеэгийн үндсэн 2 эм болох изониазид ба рифампицинд дасалтай нян хамгийн аюултай бөгөөд сүрьеэтэй тэмцэх ажилд үлэмж саад болох боллоо.

Эмэнд дасалтай сүрьеэ юунд хүргэх вэ?

- Нас баралт – эмийн дасал ихэнхдээ үхэлд хүргэдэг.
- Өвчлөл - Өвчний явц удааширч, бусад хүмүүст эмийн дасалтай нян халдаан өвчлүүлдэг.
- Өртөг – Эмчилгээний үргэлжлэх хугацаа урт 18-24 сар бөгөөд 2-р эгнээний эмүүд их үнэтэй учир гарах зардлыг ихэсгэнэ.

Сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх

1. Өвөрмөц урьдчилан сэргийлэлт /БЦЖ вакцин/

Хүүхдийг вакцинд хамруулснаар тэднийг үхэлд хүргэдэг сүрьеэгийн хүнд хэлбэрүүдээс 90 хүртэл хувиар хамгаалж чадна.

2. Сүрьеэгийн халдвар авахаас урьдчилан сэргийлэх

Уушгины халдвартай хэлбэрийн сүрьеэтэй өвчтөнг эрт илрүүлж бүрэн төгс эмчлэх нь бусдад халдвар тараахаас сэргийлэх хамгийн үр дүнтэй арга юм.

3. Сүрьеэгийн халдвар авсан хүн сүрьеэгээр өвчлөхөөс урьдчилан сэргийлэх

Сүрьеэгийн халдвар авсан хүмүүсээс сүрьеэгээр өвчлөх хүний тоог нэмэгдүүлэхгүй байхын тулд эрүүл хүмүүсийн өвчин эсэргүүцэх чадварыг бууруулахгүй байхад чиглэнэ.

Халдвартай хэлбэрийн сүрьеэгээр өвдсөн хүн эмчилгээний эхний 2 сар амны хаалт хэрэглэж, ханиаж найтаахдаа ам хамраа хааж, нус цэрээ ил задгай хаяхгүй байх хэрэгтэй. Мөн гэр, өрөө тасалгаагаа нарын гэрэл шууд тусахаар байлгаж, агааржуулалтыг сайн хийх хэрэгтэй.



ЭМСДИ-ны үүрэг юу вэ?

ЭМСДИ таны гол үүрэг бол

- Эмчлүүлэгч эмчилгээгээ зөв горимоор тасралтгүй бүрэн төгс хийлгэхэд туслах явдал юм.

- Эмчлүүлэгч эмээ ууж бүрэн төгс эдгэрэх итгэл үнэмшилтэй болоход нь туслах үүрэгтэй.

- Эмчлүүлэгч, ар гэрийнхний ойрын туслагч, найз нөхөр нь болж зовлон бэрхшээлийг нь хуваалцах явдал юм.

ЭМСДИ-ны гол үүрэг нь өвчтөн эмчилгээгээ тогтмол, зөв горимоор, бүрэн төгс хийлгэж дуусгахад туслах явдал юм.

ЭМСДИ-ны үндсэн үйл ажиллагаа:

- Бэлтгэгдсэн ЭМСДИ нь Монголын Сүрьеэтэй Тэмцэх Нийгэмлэгтэй /МСТН/ гэрээ байгуулан ажиллана.

- ЭМСДИ нь МСТН-ийн аймаг дүүрэг хариуцсан ажилтнуудын шууд удирдлаганд аймаг дүүргийн сүрьеэгийн диспансерийн эмч сувилагч нартай нягт холбоотой ажиллана.

- ЭМСДИ эмчлүүлэгчийн эмийг долоо хоногийн тодорхой товросон өдөр сүрьеэгийн кабинетаас авна. Эмийг тоо ёсоор нь хүлээн авч хаяж үрэгдүүлэлгүй зааврын дагуу нямбай хадгална.



- Эмчлүүлэгчийн эмийг ажлын 5 өдөр өдөр бүр харж уулгаад гарын үсгийг нь зуруулна.
- Эмчлүүлэгч эмчилгээгээ тасалсан тохиолдолд шалтгаан бэрхшээлийг тогтоож эмчилгээг үргэлжлүүлнэ. Хэрэв эмчлүүлэгчийг олохгүй эсвэл эмээ үргэлжлүүлэн уухыг ятгаж чадахгүй бол эмч болон МСТН-ийн аймаг дүүрэг хариуцсан ажилтанд мэдэгдэж, уулзуулна.
- Эмийн гаж нөлөө илэрсэн тохиолдолд эмчдээ хандахыг зөвлөнө.
- Эмчлүүлэгчийн ар гэрийнхнийг хавьтлын үзлэгт дуудна.
- Эмчлүүлэгчийг эмчилгээний хяналтын шинжилгээнд сүрьеэгийн диспансераас өгсөн зарын дагуу дуудна.
- Эмчлүүлэгч, ар гэрийнхэн болон олон нийтэд сүрьеэгийн урьдчилан сэргийлэлт, эмчилгээний горимын талаар мэдээлэл сургалт сурталчилгаа тогтмол явуулна.
- Танд болон эмчлүүлэгчид ажил гарсан тохиолдолд эмчлэгч эмчтэй болон МСТН-ийн аймаг дүүрэг хариуцсан ажилтантай зөвлөлдөн шийднэ.
- Сард нэг удаа тайлангийн хуралд оролцож тайлангийн хүснэгт бөглөж сарын хугацаанд хийсэн ажлаа хэлэлцэнэ.



Сүрьеэгийн эсрэг эмийг эмчлүүлэгчид хэрхэн үүлгэх вэ?

- Эмчлүүлэгчид эмээ даруулж уух усаа буцалгаж бэлэн байлгахыг сануулна

- ЭМСДИ нь эмчлүүлэгчид өгөх эмээ тоолж, зөв эсэхээ шалгасны дараа өгнө

- Бүх эмээ залгиж уухыг харна.

- Эм уулгасан хүснэгтэнд тэмдэглэж, гарын үсэг зуруулна.

ЭМСДИ та эмчлүүлэгч өдөр бүр эмээ залгиж уухыг харах хэрэгтэй.



Та их өөрчлөлтийг авчирч чадна.

Эмчлүүлэгч өдөр бүр тасралтгүй эмээ ууж, бүрэн төгс эдгэрэхэд та тусалснаараа гавьяатай. Эмчилгээгээ бүрэн төгс хийлгэхэд таны тусалсан тус үнэлж баршгүй юм. Учир нь олон арван хүн энэ аюулт өвчний халдвар авахаас хамгаалах үйлст та хүндтэй үүрэг гүйцэтгэж байна. Мөн эмчлүүлэгчийн гэр бүлийнхэнд тусалсан тусыг тэд хэзээ ч мартаггүй.

Та сүрьеэтэй эмчлүүлэгч эдгэрэхэд туслахаас гадна бусад хүмүүст сүрьеэгийн халдвар тархахаас сэргийлж чадна.

САЙН ҮЙЛС ДЭЛГЭРЭХ БОЛТУГАЙ



ЭМСДИ-ны хөтлөх хүснэгтүүд

Хүснэгт 1

Эмчлүүлэгч.....-ны 7 хоногийн эм хүлээлцсэн
бүртгэл

№	Сар өдөр	ЭМСДИ- ны нэр	Эмийн нэр	Тоо ширхэг	Хүлээн авсан ЭМСДИ- ны гарын үсэг	Аймаг дүүрэг хариуцсан ажилтны гарын үсэг	Эм хүлээлгэн өгсөн хүний гарын үсэг
1							
2							

Хүснэгт 2

Эмчлүүлэгч.....-ны эм уусан бүртгэл

Сар	Өдөр	Эм уусан бүртгэл	Эмчлүүлэгчийн гарын үсэг

Эмчлүүлэгчийн ар гэрийнхнийг хавьталын шинжилгээнд хамруулах

№	Эмчлүүлэгчийн нэр	Хавьталын нэр	Нас хүйс	Хамрагдсан эсэх	Шинжилгээний хариу	Тайлбар

Эмчлүүлэгч, түүний ар гэрийнхэнд, олон нийтэд хийсэн мэдээлэл сурталчилгаа

№	Сургалт явуулсан газар	Хамрагдсан хүний нэр	Он сар өдөр	Хамрагдсан хүний тоо	Сэдвийн нэр	Сургалтын хэлбэр	гарын үсэг

Эмчлүүлэгчийн бүртгэл

№	Овог нэр	Нас Хүйс	Гэрийн хаяг	Эмчилгээ эхэлсэн Он сар өдөр	Онош ЛУ+ У- УБЭ/	Түрхэцийн шинжилгээ					Эмчилгээ дууссан Он сар өдөр	Эмчилгээ үргэлжилсэн хугацаа	Эмчилгээний үр дүн
						0	2	5	6	8			



ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙН ДУРЫНХНЫ
ГАРЫН АВЛАГА